

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/96/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд хот

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас:70523020

Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.COM

Цахим хаяг: Lundegmaa.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Агуулга

1	Аудитын тайлан	5
1.1	Оршил	5
1.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
1.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
1.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
1.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
1.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
1.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
1.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
1.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
1.8.2	Бараа материалын данс	9
1.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
1.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
1.11	Шилэн дансны мэдээлэл	10
1.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
1.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
2	Менежментийн захидал	11
2.1	Дансны авлага, өглөгтэй холбоотой	11

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайшианд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.02.25 № 9-6/169

Танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Т. Цэцэгсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-02-15-наас 2019-02-18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-02-18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Хатанбулаг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 74 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хатанбулаг сумын ЗДТГ нь “Төр эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагаа” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын оны Төсвийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход өндөр гарч байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг тогтоов.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ 2018 оны нийт зардал 8,869.13 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 8,869.13 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцов.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	15,392.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	40,000.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар	0	0.00	

шилжүүлсэн

5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
	Дүн	3	55,392.5

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2 Бараа материалын данс

Эд хариуцагч тусгай зориулалт, сэлбэг хэрэгсэл, аж ахуй, түлш шатах тослох материалын дансдын орлогыг 8.9 сая төгрөгөөр, мөн дээрх дансдын зарлагыг 9.5 сая төгрөгөөр тус тус материалын тайланд дутуу тусгасан байна.

Энэ нь Эд хариуцагчийн эрх, үүргийн дүрмийн 17-д “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Холбогдох материалын тайланд дутуу тусгасан орлого, зарлагыг залруулан бүртгэв.

1.8.2 Үндсэн хөрөнгийн данс

Ханги суурьшлын бүсийн боомт дахь 40.0 сая төгрөгийн өртөгтэй ЗАА-ны барилгыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгийг НББ-д тусгуулах албан шаардлага өгөв.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 342,248.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардалд 341,614.5 мянган төгрөгийг зарцуулснаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 242,090.8 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 99,523.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 634.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Хатанбулаг сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дансны авлага, өглөгтэй холбоотой

2.1.1 Илрүүлэлт

Санхүүгийн тайланд 2008 онд үүссэн эзэн холбогдогч нь нас барсан 1,346.2 мянган төгрөгийн дансны авлага, аймгийн Төрийн аудитын газраас нөхөн сэргээлтийн сангийн дансанд төвлөрүүлэх 14,046.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг 2014 онд дансны өглөг дансанд тусгасан бөгөөд өнөөг хүртэл барагдуулаагүй байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж

Дансны авлага, өглөг үүссэн тухайн оны баримт материалыг нягталж, барагдуулах арга хэмжээ авах.

2.2 Зардлын данстай холбоотой

2.2.1 Илрүүлэлт

Ажил олгогчоос шилжүүлэх НДШ-ийн 1,023.1 мянган төгрөгийг цалин хөлсний зардалд шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зардал гарах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2.2 Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67,041,836.88	66,264,845.99
33	АВЛАГА	6,161,060.02	1,871,269.13
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,569.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,346,209.00	1,346,209.00
335	Бусад авлага	4,810,282.02	525,060.13
3351	Байгууллагаас авах авлага	3,986,327.02	525,060.13
35	БАРАА МАТЕРИАЛ	60,880,776.86	64,393,576.86
351	Түүхий эд материал	20,969,060.12	22,903,060.12
35110	Тусгай зориулалттай материал	20,969,060.12	22,903,060.12
354	Хангамжийн материал	13,401,516.74	15,200,316.74
35410	Бичиг хэргийн материал	3,759,160.00	5,046,420.00
35420	Аж ахуйн материал	1,308,115.00	1,250,095.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,649,600.00	4,747,300.00
35440	Түлш, шатах тослох материал	4,650,001.74	4,156,501.74
35600	Мал амьтад	26,510,200.00	26,290,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,533,419,542.40	1,645,930,849.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,533,419,542.40	1,645,930,849.44
392	Биет хөрөнгө	1,532,966,209.08	1,498,930,182.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	750,609,257.70	767,497,168.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-199,054,793.34	-15,598,936.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	198,010,906.00	199,100,906.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-110,392,896.04	-114,786,850.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,397,938.12	113,685,938.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,104,867.99	-70,246,856.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,444,485.26	43,464,485.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,381,046.64	-30,630,790.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,503,145,353.30	1,403,632,353.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-685,653,127.29	-808,132,235.03
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	00.00
39217	Ном	10,945,000.00	10,945,000.00
393	Биет бус хөрөнгө	453,333.32	147,000,666.72
39301	Програм хангамж	1,784,000.00	1,784,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,330,666.68	-1,667,333.28
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	146,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,600,461,379.28	1,712,195,695.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,047,737.00	14,046,350.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,047,737.00	14,046,350.00
413	Өглөг	16,047,737.00	14,046,350.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,927,637.00	00.00
4136	Бусад өглөг	14,120,100.00	14,046,350.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14,000,100.00	14,046,350.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	120,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,584,413,642.28	1,698,149,345.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,584,413,642.28	1,698,149,345.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,368,105,636.59	1,514,989,636.59
51101	Өмч: - төрийн	1,368,105,636.59	1,514,989,636.59
512	Хуримтлагдсан үр дүн	76,070,698.10	15,867,754.76
51210	Өмнөх үеийн үр дүн	76,070,698.10	64,759,776.84
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-48,892,022.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	140,237,307.59	167,291,954.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,600,461,379.28	1,712,195,695.43

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	549,891,702.27	837,495,514.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	190,060,577.54	389,372,503.92
120	Нийтлэг татварын бус орлого	190,060,577.54	389,372,503.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	190,060,577.54	388,494,253.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,588,500.00	5,991,400.01
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	180,472,077.54	382,502,853.91
120009	Бусад орлого	00.00	878,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359,831,124.73	448,123,010.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,170,564.73	109,934,210.10
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,485,525.73	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,125,039.00	109,684,210.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	560,000.00	250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	326,660,560.00	338,188,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	326,660,560.00	338,188,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	547,793,623.79	636,094,044.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,684,657.79	630,511,519.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,684,657.79	630,511,519.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,652,104.00	214,335,060.00
210101	Үндсэн цалин	218,652,104.00	214,335,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,296,505.00	25,950,196.00
210201	Тэтгэврийн даатгал	16,797,237.00	17,317,469.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,880,736.00	2,161,106.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,766,145.00	1,728,893.00
210204	Ажилгүйдлийн даатгал	463,608.00	431,153.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,388,779.00	4,311,575.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,633,426.29	12,097,010.00
210301	Гэрэл, цахилгаан	803,628.00	1,304,860.00
210302	Түлш, халаалт	5,829,798.29	10,792,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,786,878.96	44,916,727.00
210401	Бичиг хэрэг	2,685,355.00	3,128,060.00
210402	Тээвэр, шатахуун	30,531,671.96	29,852,277.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,098,500.00	11,500,290.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,351,352.00	316,100.00
2105	Нормативт зардал	00.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,170,300.00	7,985,500.00
210604	Урсгал засвар	4,170,300.00	7,985,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,616,600.00	4,271,000.00
210702	Дотоод албан томилолт	4,616,600.00	4,271,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,147,659.70	29,787,606.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,005,114.70	28,991,045.00
210803	Даатгалын үйлчилгээ	374,325.00	312,579.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	292,220.00	243,020.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	227,000.00
210807	Газрын төлбөр	278,000.00	13,962.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,381,183.84	290,568,420.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,343,645.01	100,278,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	180,037,538.83	190,289,780.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,108,966.00	5,582,525.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,000,000.00	5,116,800.00

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,206,800.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	630,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	180,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	465,725.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	465,725.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	108,966.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	108,966.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,098,078.48	201,401,469.06
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,686,537.40	250,293,491.14
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,686,537.40	217,073,042.29
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	33,220,448.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,686,537.40	-250,293,491.14
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	411,541.08	-48,892,022.08

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	369,419,624.73	458,978,987.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,588,500.00	6,869,650.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,588,500.00	6,869,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,588,500.00	5,991,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,588,500.00	5,991,400.00
120009	Бусад орлого	00.00	878,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359,831,124.73	452,109,337.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,170,564.73	113,920,537.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,485,525.73	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,125,039.00	113,670,537.13
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	560,000.00	250,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	326,660,560.00	338,188,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	326,660,560.00	338,188,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	360,964,624.73	449,670,987.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	360,964,624.73	449,670,987.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,869,331.71	444,373,402.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,231,047.00	215,194,471.00
210101	Үндсэн цалин	219,231,047.00	215,194,471.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,992,802.00	26,896,303.00
210201	Тэтгэврийн даатгал	15,493,534.00	17,717,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,880,736.00	2,214,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,766,145.00	1,762,603.00
210204	Ажилгүйдлийн даатгал	463,608.00	442,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,388,779.00	4,759,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,803,628.00	11,334,860.00
210301	Гэрэл, цахилгаан	803,628.00	1,304,860.00
210302	Түлш, халаалт	6,000,000.00	10,030,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,481,445.00	45,813,217.00
210401	Бичиг хэрэг	4,535,915.00	4,011,120.00
210402	Тээвэр, шатахуун	20,395,130.00	29,120,927.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,130,500.00	11,561,590.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	299,900.00	999,580.00
2105	Нормативт зардал	00.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,311,100.00	8,139,990.00
210604	Урсгал засвар	8,311,100.00	8,139,990.00
2107	Томилолт, зочны зардал	4,624,600.00	4,271,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,624,600.00	4,271,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,801,540.70	32,673,561.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,658,995.70	31,877,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	374,325.00	312,579.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	292,220.00	243,020.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	227,000.00
210807	Газрын төлбөр	278,000.00	13,962.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,623,169.01	99,250,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,623,169.01	99,250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,095,293.02	5,297,585.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,000,000.00	4,306,800.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,206,800.00

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	990,785.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	990,785.13
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,095,293.02	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,095,293.02	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,455,000.00	9,308,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,455,000.00	9,308,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,455,000.00	9,308,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,455,000.00	9,308,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,455,000.00	9,308,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,455,000.00	-9,308,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,368,105,636.59	140,332,521.36	75,563,943.26	1,584,002,101.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	95,213.76	95,213.76
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,368,105,636.59	140,332,521.36	75,659,157.02	1,584,097,314.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-95,213.76	00.00	-95,213.76
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	411,541.08	411,541.08
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,368,105,636.59	140,237,307.59	76,070,698.10	1,584,413,642.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	11,310,921.26	-11,310,921.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,368,105,636.59	140,237,307.59	64,759,776.84	1,573,102,721.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	27,054,646.49	00.00	27,054,646.49
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	146,884,000.00	00.00	48,892,022.08	97,991,977.92
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,514,989,636.59	167,291,954.08	15,867,754.76	1,698,149,345.43

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	342,248,800.00	341,614,475.00	634,325.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,248,800.00	341,614,475.00	634,325.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,248,800.00	341,614,475.00	634,325.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,788,000.00	215,194,471.00	593,529.00
210101	Үндсэн цалин	215,788,000.00	215,194,471.00	593,529.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,905,300.00	26,896,303.00	8,997.00
210201	Тэтгэврийн даатгал	17,717,000.00	17,717,000.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,214,700.00	2,214,700.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,771,600.00	1,762,603.00	8,997.00
210204	Ажилгүйдлийн даатгал	442,900.00	442,900.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,759,100.00	4,759,100.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,344,900.00	11,334,860.00	10,040.00
210301	Гэрэл, цахилгаан	1,304,900.00	1,304,860.00	40.00
210302	Түлш, халаалт	10,040,000.00	10,030,000.00	10,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,619,800.00	36,618,090.00	1,710.00
210401	Бичиг хэрэг	3,762,000.00	3,761,120.00	880.00
210402	Тээвэр, шатахуун	21,685,800.00	21,685,800.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,052,000.00	10,051,590.00	410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	999,580.00	420.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,051,000.00	12,050,990.00	10.00
210604	Урсгал засвар	12,051,000.00	12,050,990.00	10.00
2107	Томилолт, зочны зардал	4,278,000.00	4,271,000.00	7,000.00
210702	Дотоод албан томилолт	4,278,000.00	4,271,000.00	7,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,461,800.00	34,448,761.00	13,039.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,664,000.00	33,652,200.00	11,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	312,800.00	312,579.00	221.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	244,000.00	243,020.00	980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227,000.00	227,000.00	0.00
210807	Газрын төлбөр	14,000.00	13,962.00	38.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	342,248,800.00	341,971,234.00	277,566.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	336,088,800.00	335,979,834.00	108,966.00
132001	Орон нутгийн төсвөөс	336,088,800.00	335,979,834.00	108,966.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,160,000.00	5,991,400.00	168,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,160,000.00	5,991,400.00	168,600.00